



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 14,610,000.00 (арван дөрвөн сая зургаан зуун арван мянга) төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Баянчандмань-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй

2. “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Б.Сүх-Очир, Гүйцэтгэх захирал О.Эрдэнэгэрэл, “Баянчандмань-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарын шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132031426



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

Монголын Үнэт цаасны клирингийн төв ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож "Баянчандмань-АЗЗА" ТӨХК-д балансаас балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын, хуримтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа
1	Мицубиши маркийн 62-96 УБВ улсын дугаартай, PD6W0402341-арлын дугаар	2008	14,610,000.00	2,200,000.00	1 жил
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		14,610,000.00 (арван дөрвөн сая зургаан зуун арван мянга)	2,200,000.00 (хоёр сая хоёр зуун мянга)	